



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 22

Улаан-Уул

Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, 25 дугаар зүйлийн 25.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 3.1, 6.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь;

1.Төсөвт байгууллагуудын өмч хөрөнгийн тооллогоор илэрсэн хөрөнгүүдийн эзэмшүүлэх эзэмшигчийг тогтоож, байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.


2.Эзэмшигч тогтоосон хөрөнгийг бүртгэх ажлыг тухайн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг сумын Засаг дарга /Д.Цэдэнсодном/-д даалгасугай.

3.Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг төсөвт байгууллагын нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 05 дугаар сард багтаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэхийг төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГОНГОР

Ёсчилсон 2019 оны 05 сарын 21 ны өдөр

D:\dok\2019 он\тогтоол.docx

1817145

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 05 дугаар сарын 21 -ний  
өдрийн 22 дугаар тогтоолын хавсралт

ЭЗЭМШИГЧИЙГ ТОГТООЖ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ  
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Марк	Ашиглалтад орсон огноо	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Тайлбар
A	1	2	3	4	5	6	7	8
1	Соёлын төв	Микшир/аналог/	Sonic Station	2018.12.29	1	1650000	1650000	
2	Соёлын төв	Чадлын өсгөгч	MAX 2500	2018.12.29	1	1320000	1320000	
3	Соёлын төв	Чанга яригч	ASK 215	2018.12.29	2	1500000	3000000	
4	Соёлын төв	Зайны микрофон	WMU-16	2018.12.29	1	800000	800000	
5	Соёлын төв	Утастай микрофон	DM.680	2018.12.29	2	200000	400000	
<b>Соёлын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн дүн</b>								
Д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Хариуцах эзэн	Ашиглалтад орсон огноо	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Тайлбар
1	Сургууль	Номын тавиур	Байгальмаа	2019.05.21	1	30000	30000	
2	Сургууль	Номын тавиур	Одгэрэл	2019.05.21	1	30000	30000	
3	Сургууль	Номын тавиур	Ганчимэг	2019.05.21	1	65000	65000	
4	Сургууль	Өлгүүр	Долгорсүрэн	2019.05.22	1	50000	50000	
5	Сургууль	Тень	Багш нарын ерөө	2019.05.23	1	100000	100000	
6	Сургууль	Хөргөгч /2 хаалгатай/	Гал тогоонд	2019.05.24	1	500000	500000	
7	Сургууль	Ус буцалгагч том	Жижүүрт	2019.05.25	1	150000	150000	
8	Сургууль	Ус буцалгагч жижиг	Жижүүрт	2019.05.26	1	50000	50000	
<b>Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн дүн</b>					<b>8</b>	<b>975000</b>	<b>975000</b>	